МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ НООЛУУРЫН ПЛАТФОРМ

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВЛӨХ БҮЛЭГ АЖЛЫН ХЭСЭГ

MONGOLIAN SUSTAINABLE CASHMERE
PLATFORM

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВЛӨХ БҮЛЭГ

ЗОРИЛГО: МТНП-ын Удирдах хорооны үйл ажиллагаа болон ТАХ-ийн үйл ажиллагааг дараах байдлаар дэмжинэ:

- ”Тогтвортой ноолуур” хэмээх ойлголт, тодорхойлолтыг томъёолоход оролцон, санал өгөх
- Брэндүүдийг Платформтой холбох үүрэг гүйцэтгэж ижил төрлийн ойлголт, бенчмарк аргачлал тодорхойлоход хувь нэмэр оруулах
- Малчдыг дэмжих санхүүгийн механизмыг бий болгох шинэ төрлийн урамшууллыг бий болгоход санал өгч хувь нэмэр оруулах
- **Гишүүд:** Kering, Hugo Boss, Burberry, Esprit, John Lewis, Alex Begg, J Crew, Ralph Lauren, Schneider, Patagonia

Эргэх холбоо, санал зөвлөмж: Тохиромжтой арга зам

- **Нийтлэг** тодорхойлолттой байх
- Уг тодорхойлолт нь цогц, **нэгдмэл** бөгөөд байгаль орчин, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг агуулсан байхыг зорино.
- Мал, амьтны тавлаг байдлыг хангах асуудал нь тодорхойлолтын түлхүүр хэсэг байх нь хамгийн чухал
- Малчдын нийгмийн хамгааллын асуудлыг агуулсан байвал сайн
- **Resilience** буюу хүлцэлт тогтворжилтын хэм нь нийлүүлэлтийн сүлжээг бусад хүчин зүйлтэй холбох, бэхжүүлэх түлхүүр хүчин зүйл байна
- **Хэмжих хэмжүүр** нь тасралтгүй сайжруулах процессийг хангах чухал хүчин зүйл байна
- Процесс нь нийлүүлэлтийн сүлжээг хүртээмжтэй, бүх талуудын оролцоог хангасан бөгөөд олон чиглэлийн өргөн цар хүрээг хамарсан бүлгүүдийг нэгтгэсэн байна.
- Процесс нь маш олон санаачлагуудыг нэгтгэхийн сацуу бүгдийг тэгш чухалчлан, тэдний үйл ажиллагаанд суурилна.
- Шинэ стандарт бий болгохгүй байвал сайн гэж үзнэ.

Тодорхойлолтод өгөх санал зөвлөмж: Тохиромжтой арг зам

‘Би хувь хүний хувьд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг чухалчилна’

‘Малчдын нийгмийн хамгаалал хүртээмжтэй, нийлүүлэлтийн сүлжээний олон талыг хамарсан байгаа нь таалагдаж байна.’

Монголын ноос, ноолуурын салбарын тогтвортой байдал нь (нүүдлийн, бэлчээрийн) тасралтгүй, ил тод, ёс зүйтэй, малын мөрдөн мөшгих ажиллагааг хангасан, хэмжигдэхүйц процесс байх ба бүх процесс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байхад чиглэх төдийгүй мал, амьтдын тавлаг байдлыг сахин хамгаалж, нийлүүлэлтийн сүлжээг resilience байлгахад чиглэсэн үүрэг хариуцлага, ашиг тусын шударга хуваарилалтыг хангасан байхад чиглэнэ.

‘Мал, амьтны тавлаг байдлыг хангах асуудал тогтвортой ноолуурын тодорхойлолтод түлхүүр хүчин зүйл байдлаар шингэж өгсөн нь нэн тэргүүнд маш чухал явдал гэж үзэж байна.

‘Resilience буюу хүлцэлт тогтворжилтын хэм хэмжээг тойрсон агуулга, санаанууд хүчтэй бөгөөд гарцаагүй уг тодорхойлолтыг нийлүүлэлтийн сүлжээний бүхий л талуудтай хамаатуулж ойлголтыг бэхжүүлж байна.’

Санал, зөвлөмж: Тодорхой биш зүйлс

- Ёс зүйтэй, тасралтгүй гэдгийг хэрхэн ойлгох вэ?: Эдгээр ухагдахуун нь маш өргөн ойлголт бөгөөд хэрэглэгч, брэндүүд, малчид зэрэг бүх талуудад өөр өөр тодорхойлолтыг агуулна.
- Байгаль орчны нөлөөллийг хамгийн бага байлгах гэдэг ойлголт нь илүү “хариуцлагатай” ноолуур ойлголтод хамаарна. “Тогтвортой” гэдэг ухагдахуунд илүү эерэг нөлөөллийг бататгасан хэл, томъёолол шаардлагатай.
- Бүхэлдээ энгийн, хялбар тодорхойлолт гаргахад хэтэрхий урт байна уу?
- Бидэнд цогц мөрдөн мөшгих ажиллагаа эсвэл тэнцвэрт ажиллагаа хэрэгтэй юу?

Тодорхойлолтод өгөх санал хүсэлт: Бүрэн тодорхойгүй зүйлс

- Ёс зүйтэй, тасралтгүй гэдгийг хэрхэн ойлгох вэ?: Эдгээр ухагдахуун нь маш өргөн ойлголт бөгөөд хэрэглэгч, брэндүүд, малчид зэрэг бүх талуудад өөр өөр тодорхойлолтыг агуулна.

- Бидэнд цогц мөрдөн мөшгих ажиллагаа хэрэгтэй юу эсвэл тэнцвэрт байдал хэрэгтэй юу?

Монголын ноос, ноолуурын салбарын тогтвортой байдал нь (нүүдлийн, бэлчээрийн) тасралтгүй, ил тод, ёс зүйтэй, малын мөрдөн мөшгих ажиллагааг хангасан, хэмжигдэхүйц процесс байх ба бүх процесс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байхад чиглэх төдийгүй мал, амьтдын тавлаг байдлыг сахин хамгаалж, нийлүүлэлтийн сүлжээг resilience байлгахад чиглэсэн үүрэг хариуцлага, ашиг тусын шударга хуваарилалтыг хангасан байхад чиглэнэ.

- Бүхэлдээ энгийн, хялбар тодорхойлолт гаргахад хэтэрхий урт байна уу?

- Байгаль орчны нөлөөллийг хамгийн бага байлгах гэдэг ойлголт нь илүү “хариуцлагатай” ноолуур ойлголтод хамаарна. “Тогтвортой” гэдэг ухагдахуунд илүү эерэг нөлөөллийг бататгасан хэл, томъёолол шаардлагатай байна.

Санал, зөвлөмж: Асуудлыг олон талаас нь хэрхэн харав?

Байгаль орчны асуудал

- **Мал амьтны тавлаг байдал нь** тусдаа бие даасан категорит орох ёстой. Энэ нь хэрэглэгч, брэндүүдийн хувьд гол асуудал. (Гол санал, зөвлөмж)
- Монголын ямаанд хамаарах мал, амьтны тавлаг байдлын тухай ойлголтод дараах тодорхой хүчин зүйлсийг тусгах шаардлагатай: Мал, амьтны тавлаг байдлыг хангах сургалт, малын хүнд гэмтэл бэртэл, тээвэрлэлт, нядалгаа, ноос самналт г.м
- “Тогтвортой ноолуур” гарцаагүй бэлчээрийн эрүүл мэндийг анхаарч, ялангуяа малын тавлаг байдлыг алдагдуулж буй бол ихээхэн чухалчилж анхаарал хандуулах шаардлагатай.
- Байгаль орчны нөлөөллийг хамгийн бага түвшинд хүргэх төдий бус дахин сэргэх эерэг нөлөөлийг бий болгох газрын менежментийн тогтолцоог сайжруулах

Санал, зөвлөмж: Асуудлыг олон талаас нь хэрхэн харав?

Нийгмийн асуудал

- Хөдөлмөрийн асуудлаар тайлбар, зөвлөмж агуулсан байх, Жишээ нь: цагаач ажиллагсдын эрх, албадан хөдөлмөр гэх мэт.. (Гол санал, зөвлөмж)
- Сайн цалин амлахын оронд шударга, хүрэлцэхүйц цалинг тусгаж чадаж байна уу?
- ‘Зах зээлийн үнийн нөлөөтэй, ил тод байдал, гэрээний нөхцөл, тавигдах стандарт, шаардлага’ – Эдгээр нь эдийн засгийн хэсэгт тусгагдах нь зүйтэй

Эдийн засгийн асуудал

Борлуулалт, маркетинг: Үндсэн тодорхойлолтод шууд хамааралтай гэж үзэхгүй байгаа тул энэ хэсгийг оруулахгүй байхыг санал болгов. Ноолуур нь тогтвортой байж болох ч тогтвортой гэж зах зээлд байрших шаардлагагүй гэж үзэж байна. Энэ нь тухайн брэндийн өөрийн шийдэх асуудал гэж үзэв.

Санал зөвлөмж

- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хэрхэн тусгах вэ?
- Зөвхөн “сөрөг нөлөө үзүүлэхгүй” байхад төвлөрөхөөс гадна дахин сэргээх , сайжруулах асуудалд төвлөрч буй эсэхийг нягтлах – Дэлхийн нийтээр ялангуяа нөхөн сэргээх асуудалд ихээхэн анхаарлаа хандуулж буй.
- Ноолуурын ширхэглэгийн чанарын хүчин зүйлийг агуулж чадаж байна уу? (Магадгүй эдийн засгийн асуудалд хамаарна)? Хэрэв ноолуур нь өндөр чанартай ширхэгт гэдгээрээ байршиж чадвал энэ салбар тэр чигтээ илүү тогтвортой байх болно (Гол санал, зөвлөмж)
- **Мал, амьтны тавлаг байдлын** тухай асуудал нь амьтны эрхийн хамгаалах бүлгүүдийн үйл ажиллагаанд хэрхэн шингэж шаардлагатай тохиолдолд малчид болоод нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг хэрхэн хамруулах асуудлыг шигтгэж өгсөн эсэх
- Олон параметр, хэмжүүр байх тусам ач холбогдлоор эрэмбэлэх хэрэгтэй
- Одоогийн формат “Эзлэх хувийн жингийн задаргаа”-г ойлгомжтой илэрхийлэхгүй байна. Тиймээс илүү тодорхой, ойлгомжтой, ашиглахад энгийн аргачлалыг тусгаж өгөх шаардлагатай гэж үзэж байна.
- Тодорхойлолт хэт урт байна. Тиймээс энгийн болгож холбогдох задаргаа, нарийвчлалыг бусад дэмжих баримт бичигт тусгаж өгөх нь зүйтэй.
- Уг процесст бүх оролцогч талуудын оролцоог хангаж чадаж буй эсэхийг нягтлах. Ялангуяа малчид уг тодорхойлолттой танилцаж, ач холбогдлыг хэрхэн үнэлж байгааг сонирхож байна.